



*Mongolian Cashmere*

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 4 дүгээр сарын  
18-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

***Компанийн 2012 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайлангийн тухай***

Говь хувьцаат компанийн 2012 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд тус компани өнгөрсөн онд техник технологийн шинэчлэлийг хийж, бүтээгдэхүүний нэр төрөл, загвар дизайныг олшруулан, гадаад, дотоод зах зээлээ тэлэх талаар тодорхой ажлуудыг төлөвлөн, амжилттай хэрэгжүүлж ажилласнийг тэмдэглэж байна.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэхь заалтыг үндэслэн “Говь” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

Говь хувьцаат компанийн 2012 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**Д. ХҮРЭЛБААТАР**



*Mongolian Cashmere*

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 4 дүгээр сарын  
18-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

***Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
гишүүдийг батлах тухай***

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, Компанийн дүрмийн 6.9.8 дахь заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын тооллогын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

***Нэг.*** “Говь” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

1. Д. Хүрэлбаатар /УХ61111512/
2. Такеши Камбэ /TF7995260/
3. Т.Одмаа /ХА76010801/
4. Д.Гэрэлмаа /УХ65042803/ нарыг;

***Хоёр.*** “Говь” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

5. Ц. Баатарсайхан /ПБ66011274/
6. Д. Хулан /ХП68082200/
7. Хидео Савада /TG5384200/
8. Д. Наранбаатар /ЦД82062574/
9. Ц. Отгонбаатар /ПБ75100216/ нарыг тус тус сонгосныг батламжилсугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**Д. ХҮРЭЛБААТАР**



*Mongolian Cashmere*

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 4 дүгээр сарын  
18-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

***Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн  
цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай***

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг удирдлага болгон Цалин урамшууллын хорооноос оруулсан саналыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

Нэг. “Говь” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг сар бүр олгох тогтмол цалин болон гишүүдийн оролцоонд үндэслэсэн хийснээрх цалингаас бүрдэхээр тогтоосугай.

Хоёр. ТУЗ-ийн гишүүдийн тогтмол цалинг сард 500,000 төгрөг байхаар тогтоож, ТУЗ-ийн даргад сард 400,000 төгрөг, ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга нарт сард 150,000 төгрөгийн албан тушаалын нэмэгдэл цалин тооцож байхаар тогтоосугай.

Гурав. ТУЗ-ийн гишүүдэд ТУЗ-ийн хурал, Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурал зэрэгт оролцсон оролцоо тутамд 500,000 төгрөгийн оролцоонд үндэслэсэн цалинг тооцож, улиралд нэг удаа олгосугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**Д. ХҮРЭЛБААТАР**